



АШУҮИС-ИЙН ДАДЛАГАЖУУЛАХ ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Анагаах Ухааны Сургуулийн (АУС) VI дамжааны Дадлагажуулах эмнэлзүйн сургалт (ДЭС) нь 2008 оны 07-р сарын 25-нд батлагдсан төгсөлтийн өмнөх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй блок сургалтаар эзэмшсэн онолын мэдлэгийг бататган эмч дагалдан бие даан суралцаж эмнэлзүйн ур чадвараа хөгжүүлж сургалтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэхүү журам нь АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын ДЭС-аар суралцаж байгаа оюутны эмнэлзүйн дадлага хийх, сургалтыг зохион байгуулах мэргэжлийн тэнхим, дадлага удирдах эмч, сургалтын алба болон гэрээт бааз эмнэлэг тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг болно.

Хоёр. Дадлагажуулах эмнэлзүйн сургалтын удирдлага, зохион байгуулалт

- 2.1. ДЭС-ыг сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан чиглэлийн дагуу өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төрөлжсөн мэргэжлийн үндэсний төвүүд, улсын төв эмнэлгүүд, Эмнэлзүйн ур чадварыг хөгжүүлэх төвд батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 2.2. АШУҮИС-ийн захиргаа эмнэлзүйн дадлагыг энэ журмын 2.1-д заагдсан эмнэлэг, төвүүдийн эмч нартай ДЭС-нд хамтран ажиллах тухай гэрээ байгуулан АШУҮИС-ийн гэрээт багшийн үнэмлэх олгож сургалт удирдуулна.
- 2.3. АУС-ийн сургалтын албаны ДЭС хариуцсан арга зүйч нь мэргэжлийн тэнхимийн ДЭС-ын зохицуулагч багш нартай хамтран хичээл тус бүрийн удирдамжийг боловсруулан АУС-ийн захирлаар батлуулж хичээлийн жил эхлэхээс өмнө сургуулийн цахим хуудсанд байршуулна.
- 2.4. АУС-ийн захиргаа, сургалтын алба нь ДЭС-ийн хуваарийг жил бүрийн 8 сарын 25-ны дотор гаргаж мөрдүүлнэ.
- 2.5. ДЭС-ыг зохицуулагч багш нар журмын 2.1-д заасан эмнэлэг, төвүүдийн гэрээт эмч нарт (журмын 2.2 заалт) оюутнуудыг хуваарилан сургалтыг зохион байгуулж, хяналт тавьж, хариуцан ажиллана.
- 2.6. Оюутан ДЭС-ийн тойролт эхлэхийн өмнө тухайн хичээлийн дадлагын удирдамжаа А4 цаасан дээр хэвлэн авч, зохицуулагч багшийн хуваарилсан эмнэлэгт тогтоогдсон хугацаанд очиж дадлага удирдах гэрээт эмчид бүрдгүүлж удирдамжийн дагуу суралцана.
- 2.7. ДЭС-нд суралцах оюутан нь хичээлийн жилийн эхний 7 хоногт багтаан халдвараас сэргийлэх зорилготой хоолойн арчдас болон дадлага хийх эмнэлгээс



шаардах бусад шинжилгээнүүдийг өгнө. Холбогдох шинжилгээний зардлыг сургалтын төлбөрт багтаан оруулсан байна.

**Гурав. Дадлагажуулах эмнэлзүйн сургалтын явц,
хяналт, үнэлгээ**

- 3.1. ДЭС-ын зохицуулагч багш зонхилон тохиолдох 1 өвчин сонгон сургалтын 5 хоног тутамд 1 удаа 4 цагаар асуудал дэвшүүлэн багаараа хэлэлцэн (семинар) шийдвэрлэнэ.
- 3.2. ДЭС-ын зохицуулагч багш эмнэлзүйн тойролтын төгсгөлд оюутнуудын дадлагын гүйцэтгэлийг удирдамжийн дагуу шалган үнэлж дүнг “Процент”-оор илэрхийлэн ажлын 48 цагийн дотор ИСУМС-д оруулна.
- 3.3. ДЭС-д хамрагдаагүй, тухайн тойролтын 10-аас дээш хувьд оролцоогүй, дадлагыг удирдамжийн дагуу хийгээгүй, удирдамжид тусгагдсан даалгавруудын нийлбэр дүн 70%-аас бага үнэлгээ авсан бол тухайн тойролтын хөтөлбөрийг хангаагүй гэж үзэн ТЗГШ I, ТЗГШ II шалгалтад оруулахгүй
- 3.4. Эмнэлзүйн бүх тойролт дууссанаас хойш ажлын 48 цагийн дотор оюутны дүнг ИСУМС-ээс шүүн хөтөлбөрийн шаардлага хангасан оюутанд ТЗГШ I, ТЗГШ II шалгалтад орох эрхийг АУС-ийн сургалтын албанаас олгоно.
- 3.5. АУС-ийн сургалтын алба, тэнхимийн зохицуулагч багш нар товлосон хуваарийн дагуу гэрээт эмчийн удирдаж буй сургалтад тогтмол хяналт, шалгалт хийнэ.

**Дөрөв. Дадлагажуулах эмнэлзүйн сургалтын
дадлага нөхөн суралцах**

- 4.1. Журмын 3.3 заалтаар хичээл нөхөх тохиолдолд ДЭС-ын зохицуулагч багш нотлох баримтад тулгуурлан зөвшөөрөл олгох бөгөөд тухайн улиралдаа багтаан зөвхөн 1 удаа нөхөн суралцаж болно.
- 4.2. Хичээл нөхөлтийн төлбөрийг тасалсан нийт цагийг багц цагт шилжүүлэн тооцож АУС-ийн дансанд төлж, баримтыг ДЭС хариуцсан зохицуулагчид өгснөөр нөхөн суралцана.
- 4.3. Нөхөлтийг бусад тойролтуудад хүндрэл учруулахгүйгээр ИСНЭ-т ажиллах, амралтын өдрүүдэд жижүүрт гарах, тасагт ажиллах гэх мэтээр зохион байгуулна.
- 4.4. Оюутан хичээл нөхөлтийн төлбөрийг төлсөн болов ч хичээл нөхөлтийг товлосон хугацаанд хийгээгүй тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.



**Тав. Дадлагажуулах эмнэлзүйн сургалтын зохицуулагч,
удирдсан багш, эмчийн ажлын үнэлгээ**

- 5.1. ДЭС-ын хөтөлбөрийн зохицуулагчаар ажилласан багшид АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын 3.4-т заасны дагуу 1 хичээлийн жилд 200 оноог илүү цагаар тооцон хөлс олгоно.
- 5.2. ДЭС-д гэрээ байгуулан эмнэлзүйн дадлага удирдсан эмч нарт АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийн журмын 4.10.2-р заалтад уялдуулан 5 оюутныг 1 хэсэгт тооцож хөлсийг олгоно.

**Зургаа. Дадлагажуулах эмнэлзүйн сургалтын
удирдах эмчийн үүрэг, хариуцлага**

- 6.1. ДЭС удирдаж буй эмч нь дадлагажигч эмчийн сургалтаар суралцаж байгаа оюутанд тухайн байгууллагын дотоод журмыг танилцуулж, удирдамжийн дагуу эмнэлэгт ажиллах чиглэл, хувцаслалт ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагын талаар зааварчилгаа өгнө.
- 6.2. Оюутан нэг бүрээр дадлагын удирдамжийг хангуулан ажиллуулна.
- 6.3. Дадлагын явцад оюутны өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, арга зүйгээр ханган, зөвлөж, тусална.
- 6.4. ДЭС-д гэрээ байгуулан эмнэлзүйн дадлага удирдсан эмч нарт МДИ, АУС-ийн баталсан хөтөлбөрийн дагуу 1 жилд 2-3 багц цагийн сургалтад хамруулан гэрчилгээ олгоно.

Долоо. Дахин шалгалт өгөх

- 7.1. ТЗГШ I, ТЗГШ II шалгалтыг улиралд 1 удаа зохион байгуулах бөгөөд шалгалтын дүн 70% хүрээгүй Д, Ф үнэлгээ авсан тохиолдолд тухайн улиралдаа багтан 1 удаа дахин шалгалт өгнө.
- 7.2. ТЗГШ I, ТЗГШ II дахин шалгалтын дүнгээс “Оюутны үнэлгээний журам”-ын дагуу 10% хасаж эцсийн дүнг гаргана.
- 7.3. Дахин шалгалтын төлбөр ДЭС-ын тойролтын нийт багц цагийн 10%-ийн үнэлгээтэй тэнцүү байна.

---oOo---